



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 8/169

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 20 -ны өдрийн A/105 дугаар захирамжийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр явагдах газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Эрдэнэдалай (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын удирдлагын хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн ерөнхий архитектор)

Ө.Дугарсүрэн

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээллийн сан, техник, программ хангамж хариуцсан мэргэжилтэн)

Л.Гомбодорж (Мөрөн сумын газрын даамал)

Нарийн бичгийн дарга:

Б.Батмөрөн (Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)


2. Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу хариуцлагатай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Эрдэнэдалай)-д даалгасугай.

3. Ажлын хэсгийн гишүүдэд Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



6710310013